



**СҮХБААТАР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, АУДИТЫН ТАНИЛЦУУЛГА**

2015 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 06

Баруун-Урт

**Сүхбаатар аймгийн Статисткийн хэлтсийн
2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн дотоод аудит хийсэн тухай**

Дотоод аудитын зорилго

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2015 оны 05-р сарын 11-ны өдрийн 08 тоот удирдамж, 2015 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу статисткийн хэлтсийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагаа, түүний зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалтын байдлыг үндсэн баримтанд тулгуурлан, “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үнэлэлт дүгнэлт өгөхөд дотоод аудитын зорилго чиглэгдлээ.

Дотоод аудитыг СХШ-ын улсын байцаагч Т.Цэрэгбаяр 2015 оны 05-р сарын 13-ны өдрөөс эхлэн ажлын 14 хоногт хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын талаархи товч мэдээлэл

Статисткийн хэлтэс нь 9054456 тоот регистер, 127000139 тоот улсын бүртгэлийн дугаартай төрийн сан банкны 120026001 тоот дансаар санхүүгийн төлбөр тооцоогоо гүйцэтгэдэг тухайн онд 7 орон тоотойгоор орон нутгийн хэрэгцээнд суурилсан статисткийн үзүүлэлтийн хүрээг тодорхойлж, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх зорилттой ажилласан. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38-д “ төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжын дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг....заасны дагуу, Статисткийн хэлтсийн дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд төсвийг Үндэсний статисткийн хорооноос хуваарилж

аймгийн төрийн сангаар олгодог тухайн онд санхүүгийн баримтанд 1-р гарын үсгийг дарга Т.Эрдэнэбат 2-р гарын үсгийг нягтлан бодогч Ц.Азжаргал нар тус тус зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Тус хэлтэс нь 2014 онд улсын төсвөөс урсгал санхүүжилтээр 67212,8 мянга төгрөгийн орлоготой 67102,3 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган 110,5 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан ба нэмэлт санхүүжилтээр 74175,7 мянга, НДС-аас 3155,2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан ба хөрөнгийн хувьд 2014 онд 5 нэр бүхий 6078,7 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн даргын тушаалаар аклсан байна.

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардал төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Шилэн дансны хуулийг 2015 оны 01-р сарын 01 нээс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулж, Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмуудын хэрэгжилтийг хянан үзэхэд Шилэн дансны холбогдох мэдээллийг хөтөлж хэвшисэн байна.

Дотоод аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Статисткийн хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалтын байдал, холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа хэдий ч шалгалтаар дараах зөрчил дутагдал илэрлээ.

1. Сахилгын шийтгэл оногдуулсан нэр бүхий хүмүүст үр дүнгийн урамшуулал, шагнал олгосон / Төрийн албаны тухай хуулийн 26 зүйлийн 26,6-д заасныг
2. Хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулагүй / Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5 дахь заалт /
3. Санхүүгийн программд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг бүртгэх, бараа материалыг дансанд орлого авалгүй шууд зардалд бүртгэсэн нь / НББ-ийн 7-р зүйлийн 7,5 18-р зүйлийн 18,1/-д заасныг тус тус зөрчисөн байна.

Хууль зүйн туслалцаа өгсөн байдал, авсан арга хэмжээ дүгнэлт

Байгууллагын хөрөнгө, санхүүг хуулийн хүрээнд захиран зарцуулах, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, төсөв хөрөнгө зарцуулахтай холбогдон гарч байгаа хууль тогтоомжийн хүрээнд ажиллах, дагаж мөрдөх талаар 4 заалттай зөвлөмж өгч ажиллалаа.

Тус хэлтсийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, заавар, журмын дагуу санхүүгийн үйл ажиллагаа нь хэвийн хэрэгжиж, санхүү нягтлан бодох бүртгэлийг Сангийн яамнаас зөвшөөрөгдсөн "ACOLOUS" программаар боловсруулж үнэн зөв илэрхийлэгдсэн эрсдэлийн түвшин бага байна.

Зөрчлийг арилгах зөвлөмж

1. Төсөв хөрөнгийг хуулийн хүрээнд захиран зарцуулж, үргүй зардал гаргахгүй байх.
2. НББ-ийн анхан шатны баримтын иж бүрдэлийг ханган ажиллах "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 18.1 дахь заалтын дагуу дотоодын хяналтын ажлыг улам эрчимжүүлэх
3. Авто машины шатахууны зарцуулалтыг тооцохдоо дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар баталсан жишиг нормыг баримтлах
4. Байгууллагын дотоод журамыг сайжруулан шинчилэнэ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Т.ЦЭРЭГБАЯР

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т. ЭРДЭНЭБАТ

